



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/339

Номгон

Агаарын тээврийг хөгжүүлэх бодлогын
баримт бичиг боловсруулах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “б”, 30 дугаар зүйлийн 30.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хавсралтаар батлагдсан “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”, “Төрөөс иргэний нисэхийн салбарт баримтлах бодлого”, Аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх дунд болон урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан агаарын тээврийг хөгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Хишигбаатар -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд В.Наранчимэг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Гэр бүл, залуучууд, жендерийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Намуун - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцаа, уул уурхай хариуцсан бодлогын мэргэжилтэн

Д.Содномсамдан -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн

Ж.Баттөр –Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Н.Энхжаргал -Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

М.Батбаяр - “Баянхонгор - Хүн үүслийн өлгий” аялал жуулчлалын холбооны тэргүүн

Нарийн бичгийн дарга: Ж.Ганхүлэг -Баянхонгор дахь Нисэх буудлын дарга


621010865

2.

2. Аймгийн эдийн засгийн нөхцөл байдал, нийгэм олон нийтийн эрэлт хэрэгцээ, хөгжлийн нөөц боломжуудад тулгуурлан агаарын тээврийг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулан Засаг даргын зөвлөлд танилцуулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Т.Хишигбаатар) -д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН